

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/					
Тайлагнах хугацаа		2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Үнэт цаас гаргагчийн нэр: Монложистикс холдинг ХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 6381251 Үнэт цаасны код: MN00MLG05696 Утасны дугаар: 7701-5454			
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж			
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Тээврийн салбар			
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		395,858,822 ширхэг			
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Ц. Дуламсүрэн /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/ Хянасан: Г.Хишигбат /Гүйцэтгэх захирал/			
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/				
1.1	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Мянган төгрөгөөр			
		2024 он	2025 он	2026 он	
		06-р сарын 30	6 сарын 30	6 сарын 30	
		Эргэлтийн хөрөнгийн дүн	77,092,828	84,635,709	100,119,952
		Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,829,794	19,601,632	18,537,786
		Нийт хөрөнгийн дүн	85,922,623	104,237,341	118,657,738
		Өр төлбөрийн нийт дүн	38,168,329	50,973,840	59,480,767
1.2	Орлогын тайлан	Мянган төгрөгөөр			
		2024 он	2025 он	2026 он	
		06-р сарын 30	6 сарын 30	6 сарын 30	
		Борлуулалтын орлого	141,982,228	142,396,992	152,489,157
		Нийт ашиг	11,717,833	12,358,635	12,277,434
		Татвар төлөхийн өмнөх ашиг	7,589,518	8,765,831	7,431,207
		Орлогын татварын зардал	(943,316)	(1,208,437)	(910,166)
Татварын дараах ашиг	6,646,202	7,557,394	6,521,041		

1.3	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Мянган төгрөгөөр	2024 он 06-р сарын 30	2025 он 6 сарын 30	2026 он 6 сарын 30
		Өмч	118,758	118,758	118,758
		Халаасны хувьцаа	-	-	(3,604,531)
		Нэмж төлөгдсөн капитал	10,187,611	10,132,733	10,187,611
		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(176,546)	33,953	(10,130)
		Хуримтлагдсан ашиг	31,474,115	38,204,771	42,838,196
		Нийт дүн	41,603,938	48,490,214	49,529,904
		Хяналтын эрхгүй хувь оролцоо	6,150,356	7,625,771	9,647,067
		Нийт дүн	47,754,294	56,115,985	59,176,971
		1.4	Мөнгөн гүйлгээний тайлан	Мянган төгрөгөөр	2024 он 06-р сарын 30
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,862,996)			(1,370,631)	(16,719,287)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,250,282)			(2,659,703)	(2,849,576)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,266,429			3,518,646	11,569,926
Валютын ханшийн зөрүү	(271,388)			291,218	(370,535)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(13,118,237)			(220,469)	(8,369,473)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,312,034			8,708,888	12,287,515
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,193,797			8,488,418	3,918,043
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт: Хангалттай гэж дүгнэсэн.				
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт: 2026 оны эхний хагас нь Монгол Улсын тээвэр, ложистикийн салбарын хувьд экспортын өсөлтөөр дэмжигдсэн боловч импортын зах зээлийн идэвх сулрал, тээврийн өртгийн өсөлтийн нөлөө зэрэг хоёр өөр чиг хандлага зэрэгцэн ажиглагдсан бөгөөд Монложистикс Групп зах зээлийн тодорхойгүй байдал, олон улсын ложистикийн орчны өөрчлөлтөд уян хатан хандаж, урт хугацааны стратегийн хөгжлийг дэмжих төсөл, хөрөнгө оруулалт болон хамтын ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллалаа. Дэлгэрэнгүйг үйл ажиллагааны тайлангаас харна уу.				
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ Нийт актив: 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт актив 118 тэрбум төгрөгт хүрч, 2025 оны эцэстэй харьцуулахад 25%-ийн өссөн үзүүлэлттэй байна. Нийт өөрийн хөрөнгө: Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 59 тэрбум төгрөгт хүрч, 2025 оны эцэстэй харьцуулахад 7%-ийн өссөн үзүүлэлттэй байна. Ашигт ажиллагаа: 2026 оны эхний хагас жилийн байдлаар группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар татварын дараах цэвэр ашиг 6,5 тэрбум төгрөгт хүрсэн байна.				

3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт:	<table><tr><th>Харьцаанууд</th><th>2024 он 06-р сарын 30</th><th>2025 он 6 сарын 30</th><th>2026 он 6 сарын 30</th></tr><tr><td>Нийт ашгийн хувь</td><td>8.3%</td><td>8.7%</td><td>8.1%</td></tr><tr><td>Цэвэр ашгийн хувь</td><td>4.7%</td><td>5.3%</td><td>4.3%</td></tr><tr><td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td><td>14%</td><td>14%</td><td>11%</td></tr><tr><td>Нэгж хувьцаанд ноогдох ашиг</td><td>14.97</td><td>14.97</td><td>14.97</td></tr></table>	Харьцаанууд	2024 он 06-р сарын 30	2025 он 6 сарын 30	2026 он 6 сарын 30	Нийт ашгийн хувь	8.3%	8.7%	8.1%	Цэвэр ашгийн хувь	4.7%	5.3%	4.3%	Өөрийн хөрөнгийн өгөөж	14%	14%	11%	Нэгж хувьцаанд ноогдох ашиг	14.97	14.97	14.97
		Харьцаанууд	2024 он 06-р сарын 30	2025 он 6 сарын 30	2026 он 6 сарын 30																	
		Нийт ашгийн хувь	8.3%	8.7%	8.1%																	
		Цэвэр ашгийн хувь	4.7%	5.3%	4.3%																	
		Өөрийн хөрөнгийн өгөөж	14%	14%	11%																	
		Нэгж хувьцаанд ноогдох ашиг	14.97	14.97	14.97																	
		<table><tr><th>Харьцаанууд</th><th>2024 он 06-р сарын 30</th><th>2025 он 6 сарын 30</th><th>2026 он 6 сарын 30</th></tr><tr><td>Эргэлтийн харьцаа</td><td>3.26</td><td>-</td><td>5.71</td></tr><tr><td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td><td>3.25</td><td>-</td><td>3.95</td></tr><tr><td>Өрийн харьцаа</td><td>0.44</td><td>0.49</td><td>0.50</td></tr></table>	Харьцаанууд	2024 он 06-р сарын 30	2025 он 6 сарын 30	2026 он 6 сарын 30	Эргэлтийн харьцаа	3.26	-	5.71	Түргэн хөрвөх чадварын харьцаа	3.25	-	3.95	Өрийн харьцаа	0.44	0.49	0.50				
		Харьцаанууд	2024 он 06-р сарын 30	2025 он 6 сарын 30	2026 он 6 сарын 30																	
		Эргэлтийн харьцаа	3.26	-	5.71																	
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	3.25	-	3.95																	
Өрийн харьцаа	0.44	0.49	0.50																			
Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл:																						
2026 оны эхний хагаст дэлхийн тээвэр, ложистикийн салбар нь геополитикийн хурцадмал байдал, олон улсын худалдааны тодорхойгүй орчны нөлөөгөөр уламжлалт тээврийн чиглэл, дамжин өнгөрөх маршрут, хүргэлтийн хугацаа болон тээврийн өртөгт томоохон өөрчлөлтүүд гарсан нөхцөлд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэв. 2026 оны эхний хагаст уул уурхайн экспорт өндөр өсөлттэй байсан ч, дотоодын эдийн засгийн нөхцөл байдал болон импортын зах зээлийн идэвх сулрах хандлагатай байлаа.																						
Тайлант хугацаанд өрхийн зээлийн өсөлт саарч, хэрэглээний зээлийн нөхцөл чангарсантай холбоотойгоор өргөн хэрэглээний барааны борлуулалт буурч, импортын ачаа тээврийн эрэлт тодорхой хэмжээгээр саарсан байна.Үүний зэрэгцээ шатахууны үнийн өсөлт болон олон улсын тээврийн өртгийн нэмэгдэл нь импортын тээврийн зардлыг өсгөж, импортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаанд дарамт үзүүлэв.																						
2026 оны эхний хагас нь Монложистикс Группийн хувьд стратегийн хөгжлийн шинэ үе шатыг эхлүүлж, хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, харилцагчийн үнэ цэнэ болон транзит тээврийн өргөжилтийн чиглэлээр бодит ахиц гаргасан онцлох хугацаа байлаа.																						
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/: Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.																					
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ Монложистик Холдинг ХК-ийн ТУЗ-өөс Компанийн тухай хууль болон “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу дараах хэлцлүүдийг ТУЗ-өөр хэлэлцэж, баталсан бөгөөд Монголын Хөрөнгийн Биржийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.																					

4.

№	Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл	Үнийн дүн
1	Охин компаниудтай менежментийн үйлчилгээний гэрээ байгуулах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн 2026 оны 1-р сарын 22-ны өдрийн №26/ТУЗ/02 тоот тогтоол	314,700,000 төгрөг
2	Монложистикс Экүйпментс ХХК -д их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай	400,000 евротой тэнцэх төгрөг
Их хэмжээний хэлцэл: 1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл: 1		

5.

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл:

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дүн (сая.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл
1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	4,562	3,500
2. Эргэлтийн хөрөнгө	2,923	2,923	0
3. Төв Азийн Зам ХХК		3,500	-3,500
Нийт	10,985	10,985	0

1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт
Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн. Үүний дагуу ОХУ-аас 50 ширхэг 12-1293 загварын ачааны хагас вагон шинээр худалдан авсан бөгөөд 2025 оноос тээврийн үйл ажиллагаанд оролцож байна.
Уг 50 ширхэг вагоны гэрээний төлбөрт нийт 8 тэрбум төгрөгийг шилжүүлсэн бөгөөд үүний 4,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулсан.

2. Эргэлийн хөрөнгийн санхүүжүүлэлт
Охин компаниудын үйл ажиллагааг өргөжүүлэх, өсөлтийг дэмжих, стратеги төлөвлөгөөг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нийт 2,9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулсан.

3. Шинэ бизнес: М&А - Төв Азийн Зам ХХК
Монложистикс Холдинг ХК нь 2024 онд автомашины импортын тээвэрлэлт хийдэг Төв Азийн Зам ХХК-ийн хяналтын багц буюу 51%-ийг худалдан авсан билээ. Энэхүү хөрөнгө оруулалтад 3,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулсан.

6.

Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 87.39%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд:

- Гүйцэтгэх захирал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г.Хишигбат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э.Оюунбилэг компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;

3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н.Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцлоо.

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 3 дахин нэмэгдсэн нь энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хурлын онцлог байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар:

1. Монложистикс Холдинг ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг;
2. Монложистикс Тракинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлага, хөрөнгө, өр төлбөрийг бүхэлд нь Монложистикс Холдинг ХК-д нэгтгэх, компани нэгтгэх гэрээг байгуулахыг зөвшөөрлийг тус тус баталсан.

• **ТУЗ-ийн ажлын товч тайлан**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Хурдацтай өөрчлөгдөж буй бизнесийн талбарт үүсч болох эрсдэл ба боломжийг амжилттай удирдах чадвартай, салбар салбартаа мэргэшсэн, туршлагатай гишүүдээс Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл бүрддэг бөгөөд ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй. Тайлант хугацаанд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

• **ТУЗ-ийн хурал**

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ нь 2026 оны эхний хагас жилд ээлжит болон ээлжит бус нийт 4 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 91,6%. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх болон ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар 2026 оны эхний хагас жилд ТУЗ-өөс нийт 32 тогтоол шийдвэрийг баталсан.

• **ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал**

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2026 оны эхний хагас жилд биечлэн болон цахим хэлбэрээр нийт 8 удаа хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажиллаж байна.

• **Хяналтын тогтолцоо**

Монложистикс Группийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцыг бэхжүүлж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Дотоод аудитын дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталлаа. Уг төлөвлөгөө нь глобал дотоод аудитын стандарт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон хүлээлтэд нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд компани үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоотой уялдсан болно.

Дунд хугацааны стратегийн тэргүүлэх чиглэл нь:

- Эрсдэлд суурилсан аудитын төлөвлөлт
- Чанар ба стандартад нийцүүлэлт
- Мэдээллийн технологи ба дата анализ
- Хүний нөөц ба чадавх
- Хамтын ажиллагаа ба уялдаа холбоо

байхаар тодорхойлж, дотоод аудитыг эрсдэлд суурилсан байдлаар төлөвлөхөд анхаарах, гол бизнесийн процессын үлдэгдэл эрсдэлийн түвшинг 3 жилийн хугацаанд 15%-иар бууруулахад хувь нэмэр оруулах, өндөр эрсдэлтэй зөвлөмжийн хэрэгжилтийн хувийг өсгөх замаар Дотоод аудитын нэгжийг компанийн стратегийн шийдвэр гаргалтад өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ, зөвлөх

	үүргээр оролцдог, бодлогын түвшинд нөлөөтэй стратегийн түнш болгон төлөвшүүлэх зорилт тавин ажиллаж байна. Дунд хугацааны стратегийн хүрээнд 2026 оны дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, хамрах хүрээний дагуу эхний хагас жилд ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг үнэлэх, үр дүнтэй, үр нөлөөтэй байдлыг хангах, сайжруулах боломжийг тодорхойлох тогтолцооны дотоод аудит болон эрсдэл, засаглал ба хяналтын орчны хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх хараат бус дотоод аудитор ажиллалаа.
--	--

6.	Үнэт цаас гаргагчтай холбоотой тайлан, мэдээлэл
----	---

	Компанийн засаглалын зарчмуудыг зөв зохистой хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдогдолтой. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг нээлттэй хувьцаат компани дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй нийт 112 хувьцаат компанийн кодексийн хэрэгжилтийн 2025 оны жилийн дундаж үнэлгээ 61.8 хувьтай гарсан бол Монложистикс Холдинг ХК-ийн кодексийн хэрэгжилт 93,1% буюу засаглалын хувьд эрсдэлгүй гэсэн үнэлгээг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажуулсан. <i>Үйл ажиллагааны хагас жилийн дэлгэрэнгүй тайлантай танилцана уу.</i>
--	---

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г. Хишигбат
 Албан тушаал: “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал
 Гарын үсэг:
 (Тамга гэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2026-07-24

Овог, нэр: Ц. Дуламсүрэн
 Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
 Гарын үсэг:

2026

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

01 Бидний тухай

Компанийн тухай	4
Хуулийн этгээдийн мэдээлэл	5
Үнэт зүйлс	6
Группийн бүтэц	7
Группийн түүхэн замнал	8
Онцлох үйл явдал	10
Онцлох тээвэр	12

02 Компанийн стратеги

Дэлхийн тээвэр ложистикийн салбар	15
Монголын тээвэр ложистикийн салбар	15
Монложистикс Групп	16
Алсын хараа 2030	17
2030 стратеги	18
Бизнес модель	18
Хагас жилийн тоон үзүүлэлтүүд	20

03 Тогтвортой хөгжил

Logistics: Дэлхий рүү тэмүүлсэн он жилүүд	25
Сагсан бөмбөгийн спортыг дэмжигч	26
Улсын биологийн олимпиадыг ивээн тэтгэгч	27
Хүний нөөцийн мэдээлэл	27


04 Засаглал

Хувьцаа эзэмшигчдын бүтэц	29
Засаглалын бүтэц, үйл ажиллагаа	29
Төлөөлөн удирдах зөвлөл	30
Ногдол ашгийн бодлого	32
Хувьцаа эргүүлэн авах хөтөлбөр	32

05 Санхүүгийн мэдээлэл

Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	34
Нэгтгэсэн санхүү байдлын тайлан	35
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	36
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	38

АГУУЛГА



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БИДНИЙ ТУХАЙ

КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 7 охин компани, 180 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэгч групп компани болсон байна. Монложистикс Групп нь Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр ложистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уурхайн түүхий эдийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг, карго зэрэг тээвэр ложистикийн бүх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр байна.

Өнгөрсөн 20 жилийн турш бид харилцагч, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэж ажилласаж ирсэн бөгөөд эдүгээ бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараараа тээвэр ложистикийн салбартаа тэргүүлэгч групп компани болжээ.

Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг толгой компани юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО

**ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ БРЭНД**

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

Монложистикс Холдинг ХК

Хэлбэр:

Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:

6381251

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэл:

**Менежментийн зөвлөх үйлчилгээ,
төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн индекс:

**Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20
Хувьцааны бүртгэлийн I ангилал**

Монголын Хөрөнгийн Бирж дээрх симбол:

MSE:MLG

Утас:

+976 7701-5454

Имэйл:

info@monlogistics.mn

Вэбсайт:

www.monlogistics.mn

Фэйсбүүк хуудас: **Monlogistics Group**

Албан ёсны хаяг:

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпын гудамж, Нью
Хоризонс оффис, 1101 тоот**



ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.




Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.



ГРУППИЙН БҮТЭЦ

Монложистикс Групп нь толгой компани болох Монложистикс Холдинг ХК болон түүний охин компаниуд гэсэн бүтэцтэйгээр ажилладаг. Монложистикс Холдинг ХК нь охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдэнд менежментийн үйлчилгээ үзүүлж, стратегийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.



Монложистикс Экспресс ХХК, Монложистикс Тракинг ХХК-иуд нь 2026 оноос Монложистикс Ворлдвайд ХХК-тай бүтэц, үйл ажиллагаагаа нэгтгэсэн.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

2005 он



Монложистикс Ворлдвайд ХХК ууган компани байгуулагдав.

2006 он

Монголын Тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2009 он



Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн авав.



Монложистикс Холдинг ХХК Толгой компани байгуулагдав.



Монложистикс Транзит ХХК байгуулагдав.



Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.

2020 он



Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

2019 он



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Каус Аустралис ХХК-ийг байгуулав.

2018 он



Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

2021 он

2022 он

2023 он

2010 он

Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас Гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийг авав.



2011 он

Монголын гаалийн зуучлагчдын нэгдсэн холбооны гишүүнээр элсэв.

2014 он

Олон улсын тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

Rebranding
"Upgrade 10" төслийг амжилттай эхлүүлэв.



ISO 9001:2008 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэв.

2017 он



Төв Азийн Зам ХХК-ийн 51%-ийг худалдан авч, M&A хийв.

2016 он



Компанийн үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиов.

2015 он



Дунд хугацааны стратегийг тодорхойлов.

2024 он

2025 он


2026 он

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“Ложистик форум 2026” амжилттай зохион байгуулагдлаа.

Монложистикс Холдинг ХК-ийн санаачлагаар анх зохион байгуулагдаж эхэлсэн Монголын болон бүс нутгийн тээвэр ложистикийн салбарын хөгжлийн чиг хандлага, бодлогын шинэчлэл, хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцдэг салбарын томоохон арга хэмжээ болох “Ложистик Форум 2026” арга хэмжээг Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо тав дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

Дэлхий дахинд үүсээд буй түлш, шатахуун тээвэрлэлтийн нөхцөл байдал, геополитикийн хурцадмал байдлаас Монгол Улсын тээвэр, ложистикийн салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөө, төмөр зам болон авто тээврийн дэд бүтцийн сорилтууд, хил боомтын нэвтрүүлэх чадвар, тээвэрлэлтийн зардлыг бууруулах боломж зэрэг салбарын тулгамдсан асуудлуудыг өргөн цар хүрээнд хөндсөн энэхүү форумд Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Хишигбат дэлхийн болон бүс нутгийн ложистикийн чиг хандлагын талаар илтгэл тавьж, панел хэлэлцүүлэгт оролцсон.



“Transport Logistic Shanghai 2026” олон улсын үзэсгэлэнд оролцлоо.

Монложистикс Групп нь Ази тивийн тээвэр ложистик, нийлүүлэлтийн сүлжээний менежментийн хамгийн томоохон үзэсгэлэнгийн нэг болох “Transport Logistic Shanghai 2026” арга хэмжээнд амжилттай оролцлоо. БНХАУ-ын Шанхай хотноо 50,000 гаруй м² үзэсгэлэнгийн талбайд, дэлхийн 50 гаруй улсын 900 орчим байгууллага, салбарын төлөөлөгчид цугларсан энэхүү үзэсгэлэнд Монложистикс Группийн охин компаниуд өргөн бүрэлдэхүүнтэй оролцож, дэлхийн тэргүүлэх компаниудтай бизнесийн шинэ харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллахын зэрэгцээ Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын хөгжил, боломж, чадавхыг олон улсын зах зээлд илүү сурталчлан танилцууллаа.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“Монголын хөрөнгө оруулалтын форум”-д оролцлоо.

БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулагдсан Монголын хөрөнгө оруулалтын форумд олон улсын 200 гаруй компанийн 300 гаруй төлөөлөгч оролцож, Монгол Улсын уул уурхай, эрчим хүч, тээвэр ложистик, технологийн салбарын тэргүүлэх компаниудтай уулзан, хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцлээ. Энэхүү форум нь Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш, стратегийн чухал хөрш болох БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, хоёр улсын хөрөнгө оруулалтын харилцааг улам бэхжүүлэхэд чиглэсэн томоохон арга хэмжээ болсон юм.

Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Хишигбат “Монгол Улсын ложистикийн салбар дахь хөрөнгө оруулалтын боломжууд” сэдвээр тус форумд илтгэл тавьж, Монголын ложистикийн зах зээлийн өсөлт, компанийн стратегийн чиглэл, 2030 он хүртэл хэрэгжүүлэх дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг танилцууллаа.



ЛэндМН ББСБ ХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Монголын хамгийн анхны финтек компани болох ЛэндМН ББСБ ХК -тай хамтран тээвэр ложистикийн салбарт Монголд анх удаа санхүүгийн уян хатан нөхцөл бүхий дижитал шийдлийг нэвтрүүлэхээр “Хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд тээврийн салбарт орчин үеийн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, илүү хурдан, хялбар, хүртээмжтэй шийдлийг хэрэглэгчдэд санал болгон ажиллах юм.

monlogistics
GROUP



lendmn

ХАМТРАЛ

ОНЦЛОХ ТЭЭВЭР

Зуурмагийн үйлдвэрийн 10 машин тээвэр

Max Machinery Industry компанийн Zoomlion 120 болон 180 загварын бетон зуурмагийн үйлдвэрийн нийт 10 машин тээврийг 2026 оны нэгдүгээр улиралд амжилттай гүйцэтгэв. Төслийн мэргэжлийн зохион байгуулалт, овор хэтрүү ачааны стандарт, бэхэлгээ, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллалаа.



Хүнд даацын тоног төхөөрөмжүүд

Нэгдүгээр улиралд мөн Эрдэнэт үйлдвэрийн тус бүр нь 77.9 тонн жинтэй 2 ширхэг хүнд тоног төхөөрөмжийг Герман улсаас Эрдэнэт хот хүртэлх олон улсын тээврийг амжилттай зохион байгууллаа.



ОНЦЛОХ ТЭЭВЭР

Нисдэг тэрэгний тээвэрлэлт

Улаанбаатар – Эрээн чиглэлд нисдэг тэрэгний экспортын тээвэр буюу үнэ цэнтэй, эмзэг ангиллын ачааг шаардагдах аюулгүй ажиллагаа, нарийн зохион байгуулалтыг хангаж, хил дамнасан тээврийг амжилттай зохион байгуулав.



Үзэсгэлэнгийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт

Юнител ХХК 20 жилийн ойгоо тохиолдуулан харилцаа холбооны түүхийг дижитал шийдлүүдээр дамжуулан хүргэх зорилготой зохион байгуулсан “Өртөө” үзэсгэлэнгийн тоног төхөөрөмж, тайзны хэрэгсэл бүхий ачааг амжилттай тээвэрлэлээ. БНХАУ -аас тээвэрлэсэн өндөр үнэ бүхий эмзэг мэдрэмтгий уг ачааг, гаальгүй түр горимоор /ATA Carnet/ оруулж, үзэсгэлэнгийн дараа буцаан тээвэрлэж, хугацаанд нь хүргэсэн.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

КОМПАНИЙН СТРАТЕГИ

ДЭЛХИЙН ТЭЭВЭР, ЛОЖИСТИКИЙН САЛБАРЫН ЗАХ ЗЭЭЛ

2026 оны эхний хагаст дэлхийн тээвэр, ложистикийн салбарт геополитикийн хурцадмал байдал, олон улсын худалдааны тодорхойгүй орчны нөлөө хэвээр үргэлжилж, уламжлалт тээврийн чиглэл, дамжин өнгөрөх маршрут, хүргэлтийн хугацаа болон тээврийн өртөгт чухал нөлөө үзүүлсэн хэвээр байлаа. Энэхүү нөхцөл байдал нь салбарын оролцогчдын өмнө маш олон сорилтуудыг бий болгож, нийлүүлэлтийн сүлжээний уян хатан байдал, эрсдэлийн удирдлагыг улам бүр чухалчлах шаардлагыг бий болгосноор байна. ОХУ-Украины зөрчил болон АНУ-БНХАУ хоорондын худалдааны хориг арга хэмжээнээс гадна 2026 онд Ойрхи Дорнод дахь мөргөлдөөний улмаас газрын тосны голлох нийлүүлэлтийн сувгуудад доголдол үүсч, улмаар дэлхийн газрын тосны үнэ богино хугацаанд өссөнөөр аль хэдийнэ хүндрэл, сорилттой тулгараад байсан тээвэр, ложистикийн салбарын үйл ажиллагаанд нэрмээс болов. Гэхдээ үйл ажиллагааны зардал өсөж, зах зээлийн таагүй нөхцөл байдал үргэлжилсэн ч дэлхийн худалдааны урсгал харьцангуй тогтвортой хадгалагдлаа.



МОНГОЛ УЛСЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

Монгол Улсын хувьд энэ оны эхний хагаст уул уурхайн экспорт өндөр өсөлттэй байсан ч, дотоодын эдийн засгийн нөхцөл байдал болон импортын зах зээлийн идэвх сулрах хандлагатай байв. Үүнийг өрхийн зээлийн өсөлт саарч, хэрэглээний зээлийн нөхцөл чангарсан зэрэг шалтгаануудтай холбож тайлбарлах боломжтой бөгөөд улмаар өргөн хэрэглээний барааны борлуулалт буурч, импортын ачаа тээврийн эрэлт тодорхой хэмжээгээр саарсан үр дүнг авчирлаа. Үүний зэрэгцээ шатахууны үнийн өсөлт, хомсдол болон олон улсын тээврийн өртгийн нэмэгдэл нь импортын тээврийн зардлыг өсгөж, импортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаанд үлэмж дарамт үүсгэх болов. Нөгөөтэйгүүр нүүрс, зэс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт эрэлт өндөр хэвээр хадгалагдаж, экспортын тээврийн тоон үзүүлэлтэд эерэг нөлөөг бий болгосон байна. Мөн Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр зам болон Багахангай-Хөшигийн хөндийн төмөр замын төслүүд төлөвлөгөөний дагуу үргэлжилснээр Монгол Улсын экспортын хүчин чадал, хил дамнасан ложистикийн үр ашгийг нэмэгдүүлэх хүлээлт улам бодит болж, урт хугацааны суурь бэхжих чухал алхам боллоо. 2026 оны эхний хагас жилийг дүгнэж харвал Монгол Улсын тээвэр, ложистикийн салбарын хувьд экспортын өсөлт нэмэгдсэн боловч импортын зах зээлийн хэмжээ бага зэрэг хумигдаж, тээврийн өртгийн өсөлтийн нөлөө чухал хүчин зүйл хэвээр хадгалагдахаар байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

Тайлант хугацаанд Монложистикс Групп дээрх гадаад орчны өөрчлөлтөд уян хатан хандаж, хурдтай шийдвэр гаргалт, урт хугацааны стратегийн хөгжлийг дэмжих төсөл, хөрөнгө оруулалт болон хамтын ажиллагааг улам эрчимжүүлэхэд голлон анхаарч ажиллалаа. 2026 оны эхний хагаст Группийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө “Vision 2030”-г шинэчлэн боловсруулж, өсөлтийн стратеги, хөрөнгө оруулалтын бодлого, дижитал шилжилт, хүний нөөцийн хөгжлийн зорилтуудаа дараагийн 5 жилээ харж тодорхойлов. Мөн олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гадаад түншлэл, бизнесийн харилцаагаа бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж, шинэ зах зээл болон стратегийн түншүүдтэй хамтын ажиллагааны суурийг өргөжүүллээ. Харилцагчийн сэтгэл ханамж, урт хугацааны хамтын ажиллагааг дэмжих зорилгоор харилцагчийн “Loyalty” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь үйлчилгээний үнэ цэнийг нэмэгдүүлэх, үнэнч харилцагчдыг тогтвортой хадгалах

шинэ механизмыг бүрдүүлж чадсан гэдэгт итгэлтэй байна. Үүний зэрэгцээ өсөн нэмэгдэж буй төмөр замын транзит тээврийн зах зээлд группийн эзлэх хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор бонд гаргаж, шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж чадсан нь онцлох үйл явдлуудын нэг боллоо. Дотоодод бизнесийн процессын автоматжуулалт, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоо болон дижитал шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж, үйл ажиллагааны үр ашиг, удирдлагын шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлсэн нь дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэхэд цаашид томоохон түлхэц, суурь чадамж болох юм. Ийнхүү 2026 оны эхний хагас нь Монложистикс Группийн хувьд стратегийн хөгжлийн шинэ үе шатыг эхлүүлж, хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, харилцагчийн үнэ цэн болон транзит тээврийн өргөжилтийн чиглэлээр бодит ахиц гаргасан чухал цаг үе болж өнгөрлөө.



АЛСЫН ХАРАА 2030

Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол Улсыг Ази, Европыг холбосон ложистик төв болгоно. Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.



2030 СТРАТЕГИ

Монложистикс Групп нь өсөлтийн 4 стратеги, тогтвортой хөгжлийн 4 стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



БИЗНЕС МОДЕЛЬ

Олон улсад нийлүүлэлтийн сүлжээг удирдах хэлбэр 1PL загвараас 5PL хүртэл хөгжөөд буй бөгөөд Монложистикс Группийн хувьд өөрийн харилцагч байгууллагуудын ачааг тээвэрлэх тээврийн шинэ маршрутыг хөгжүүлснээр геополитикийн хүндрэлээс үүсэж буй тээвэрлэлтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллагч түншийн харилцаа болон дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр тээвэрлэлтийн хямд бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг санал болгож, өөрийн 3PL бизнес моделийг хөгжүүлэн ажиллаж байна.



3PL загвар нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний олон асуудлыг хариуцдаг мэргэжлийн ложистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниас Ачааг хүлээн авах, Тээвэрлэх, Хадгалах, Савлах, Шошголох, Хүргэлт хийх гэх мэт үйлчилгээг авч байгаа хэлбэр юм. 3PL үйлчилгээ үзүүлэгчид нь илгээгч болон тээвэрлэгчдийн хооронд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж, үр ашгийг оновчтой болгох, зардлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн гинжин хэлхээний ложистикийг удирддаг. 3PL үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйлчилгээг ашигласнаар бизнес эрхлэгчид үндсэн бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, ложистикийн хэрэгцээгээ туршлагатай мэргэжилтнүүдэд даатгаж чаддаг.

Бидний хувьд ачаа илгээгчээс хүрэх эцсийн цэг буюу ачаа хүлээн авагчид очих хүртэл тээвэр, ложистикийн бүхий л үйлчилгээг харилцагчдадаа санал болгодог. Үүнд тээврийн захиалга хүлээн авах, ачаа барааг илгээгчээс хүлээн авахаас өгсүүлээд агуулахын үйлчилгээ, баримт бичиг гаалийн бүрдүүлэлт хийх, ачааг тээврийн хэрэгсэлд ачих, бэхлэх, нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шуурхай шилжүүлэн ачих гэх мэт цогц үйлчилгээ багтдаг. Түүнчлэн олон улсад тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг нэр хүндтэй, туршлагатай түншүүдтэй хамтран эдгээр цогц үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ бүх ачааг эрсдэлээс хамгаалж, даатгалд хамруулдаг нь бидний давуу тал, онцлог юм.

Тээврийн цогц үйлчилгээ

Тээврийн захиалга авах – Ачаа барааг хүлээн авах – Агуулахад хадгалах – Баримт бичиг болон гаалийн бүрдүүлэлт хийх – Ачаа барааг бэхлэх – Худалдан авалтын менежмент – Тээврийн хэрэгсэл хооронд шуурхай шилжүүлэн ачих – Даатгал

А
Ачаа
илгээгч



Эхний цэгээс эцсийн цэг хүртэлх ложистикийн цогц үйлчилгээ

Бид дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй олон улс дах түншүүдтэйгээ хамтран ачаа илгээгчээс ачаа хүлээн авагч хүртэлх тээврийн өргөн сонголт бүхий цогц үйлчилгээг үзүүлдэг. Мөн бид өөрсдийн үйлчилгээний байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөлд анхаарлаа хандуулахын зэрэгцээ үйл ажиллагааны оновчтой байдлыг чухалчилдаг.



Тээвэрлэгчийн гэрээт туслан гүйцэтгэгч



В
Ачаа хүлээн
авагч




Ложистикс болон түгээлтийн үйлчилгээ

Агуулахад хадгалах — Боож, баглах — Шилжүүлэн ачих — Хаягжуулалт, угсралт, шалгалтыг хийж гүйцэтгэх — Гаалийн бүрдүүлэлт — Баримт бичиг — Нийлүүлэлтийн гинжин хэлхээг оновчтой зохион байгуулах — 4PL

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО


/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /



2026 оны II улирлын байдлаар Монгол Улсын тээврийн салбарын орлого 6.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24%-иар өссөн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО


/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /



2026 оны II улирлын байдлаар Монложистикс Группийн орлого 155 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.5%-иар өссөн байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ


/ САЯ ТОННООР /



2026 оны II улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн хэмжээ 80.6 сая тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 33.7%-иар өссөн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн нийт ачаа тээврийн хэмжээ 418 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 11%-иар өссөн байна.

ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛС


/ САЯ ТОННООР /



Монгол Улсын импортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.4%-иар өсөж, 3.7 сая тоннд хүрсэн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн импортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13%-иар өсөж, 76 мянган тоннд хүрсэн байна.

ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛС


/ САЯ ТОННООР /



Монгол Улсын экспортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27%-иар өсөж, 54.6 сая тоннд хүрсэн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн экспортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 37%-иар буурч, 10 мянган тоннд хүрсэн байна.

ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛС


/ САЯ ТОННООР /



Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үетэй ойролцоо буюу 2.9 сая тонн байлаа.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн зохион байгуулсан транзит ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11%-иар өсөж, 324 мянган тоннд хүрсэн байна.

ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /



Монложистикс Группийн гадаад улс доторх ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 198%-иар өсөж, 9.2 мянган тоннд хүрсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд компани гадаад, дотоод орчны эрсдэл, боломжууд, нөхцөл байдлыг харгалзан үзэж, бүхий л оролцогч талуудад урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтийг бий болгоход анхаарч ажиллаж байна.

“Logistics: Дэлхий рүү тэмүүлсэн он жилүүд”

Тээвэр ложистикийн салбарын түүхэн үүсэл, хөгжлийн үе шат, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө, зах зээлийн шилжилтийн үед оруулсан хувь нэмэр, одоо тулгарч буй сорилт, хэтийн ирээдүйг нэгдсэн байдлаар тусгаж, анхаарч авч үзсэн эх сурвалж, баримт бичиг хомс байдгийг харгалзан, манай хамт олон 20 жилийн ойгоо тохиолдуулан салбарынхаа түүхийг нэгтгэж, зөвхөн Монгол Улсынхаа төдийгүй дэлхийн тээвэр ложистикийн хөгжил, туулж ирсэн зам, хуримтлуулсан туршлага, цаашдын чиг хандлагын таамаглал гэх зэргээр ложистикийн салбарын нэгдмэл дүр төрхийг дэлгэн харуулах номыг эрхлэн гаргахыг зорьсоны үр дүнд “Logistics: Дэлхий рүү тэмүүлсэн он жилүүд” ном хэвлэгдэн гарлаа. Тээвэр ложистикийн салбарын мэргэжилтнүүд, энэ мэргэжлээр суралцагч оюутан залуучууд, салбарын талаар мэдлэг, мэдээлэл авахыг хүсэх бүх хүмүүст хүртээмжтэй нэгэн бүтээл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.



Нийслэлийн шилдэг татвар төлөгч

Монложистикс Транзит ХХК нь Нийслэлийн хэмжээнд шилдэг татвар төлөгч 29 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарлаа.

Монложистикс Транзит ХХК нь олон улсын тээвэр зуучлалын чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж, Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит тээврийг харилцагч, түншүүдтэйгээ хамтран найдвартай зохион байгуулсаар байна. Энэхүү үйл явдал нь компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, нийгмийн хариуцлагын нэг том илэрхийлэл юм.



Сагсан бөмбөгийн спортыг дэмжигч

Монголын сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулж, баг тамирчдын амжилтанд дэмжлэг үзүүлэх зорилготой Монложистикс Групп болон Монголын сагсан бөмбөгийн шилдэг багуудын нэг болох Сэлэнгэ Бодонс, хөгжлийн лигийн Умардын буганууд багуудтай хамтын ажиллагаа амжилттай үргэлжилж байна. Сэлэнгэ Бодонс баг Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Үндэсний Дээд Лиг (The League)-ийн 2025–2026 оны улиралд клубын түүхэн дэх хамгийн өндөр амжилтын нэгийг үзүүлж, аваргын төлөө хүчтэй өрсөлдөн улмаар улирлын Дэд аварга, мөнгөн медалийн эзэд болсон бол Умардын буганууд баг М Хөгжлийн лигийн 2025–2026 оны улирлын Хүрэл медалийг хүртсэн билээ.




Улсын биологийн олимпиадыг ивээн тэтгэгч

Монложистикс Групп нь нийгмийн хариуцлага болон тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилтийн эсрэг суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)”-ыг эх орондоо зохион байгуулж буй түүхэн үйл явдалтай уялдуулан “Цөлжилтийн эсрэг биологийн шийдэл” уриан дор зохион байгуулагдсан Улсын биологийн 36 дахь удаагийн олимпиадыг ивээн тэтгэн хамтран ажиллалаа.

Энэхүү олимпиад нь биологийн шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, байгаль орчны боловсролыг дэмжих, сурагчдын судалгаа шинжилгээний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний хэмжээний томоохон арга хэмжээ юм.

Тус олимпиадын онцлог нь бүх шатны шалгаруулалтыг бүрэн цахим системд суурилан зохион байгуулснаар ойролцоогоор 400 боодол бичгийн цаас хэмнэж, цаасны хэрэглээг бууруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгасан “ногоон олимпиад” болсон явдал байв. Энэхүү санаачилга нь тогтвортой хэрэглээ, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлсэн сайн жишээ болж, оролцогчид болон боловсролын байгууллагуудад байгальд ээлтэй шийдлийг түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа.



Монложистикс Групп нь боловсрол, шинжлэх ухаан, байгаль орчны хамгааллыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй нийгмийн хариуцлагын үйл ажиллагаагаа цаашид тогтвортой үргэлжлүүлж, ирээдүй хойч үеийн мэдлэг, ур чадвар, байгаль орчны ухамсрыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулахыг зорин ажиллаж байна.



Хүний нөөцийн тоон мэдээлэл

Монложистикс Групп нь 2026 оны эхний хагас жилд 8 компанийн нийт 182 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт ажилтнуудын тоо: **182**




Эрэгтэй 37%

Эмэгтэй 63%

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

I. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 87.39%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г.Хишигбат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж;
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э.Оюунбилэг компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н.Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцлоо.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар:

1. Монложистикс Холдинг ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг;
2. Монложистикс Тракинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлага, хөрөнгө, өр төлбөрийг бүхэлд нь Монложистикс Холдинг ХК-д нэгтгэх, компани нэгтгэх гэрээг байгуулахыг зөвшөөрлийг тус тус баталсан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Лувсанжамба
ГАНЗОРИГТ

Үүсгэн байгуулагч ба
ТУЗ-ийн дарга

Санхүү, олон улсын худалдааны
чиглэлээр 32 жилийн туршлагатай.



Бааст
ТЭЛЭНГЭД

Үүсгэн байгуулагч, ТУЗ
ийн ердийн гишүүн

Тээвэр ложистикийн салбарт 32
жилийн туршлагатай.



Ганзоригт
ХИШИГБАТ

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүү, хөрөнгө оруулалтаар
12 жил, засаглал удирдлагын
чиглэлээр 9 жилийн
туршлагатай.



Өлзийбаяр
ГАНЗОРИГ

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт
24 жилийн засаглал, гүйцэтгэх
удирдлагын туршлагатай.



Эрэндоо
ОЮУНБИЛЭГ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Банк санхүүгийн салбарт 32
жилийн компанийн засаглалын
мэргэшсэн туршлагатай.



Балдан
ЭНХТҮВШИН

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт
22 жилийн засаглал, гүйцэтгэх
удирдлагын туршлагатай.



Санжаа
САЙНБАТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Худалдаа үйлчилгээний салбарт
засаглал удирдлагын чиглэлээр
22 жилийн туршлагатай.



Готов
ЦЭРЭНПҮРЭВ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Олон улсын банк санхүүгийн
салбарт 42 жилийн удирдах
чиглэлийн туршлагатай.



Сэнгэ
ЭНХ-АМГАЛАН

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бизнесийн удирдлага, засаглал,
гүйцэтгэх удирдлагын 24 жилийн
туршлагатай.



Цогт
ДУЛАМСҮРЭН

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Хүний нөөц, захиргаа, эрх
зүй, засаглалын 22 жилийн
туршлагатай.

II. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн хурал

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ нь 2026 оны эхний хагас жилд ээлжит болон ээлжит бус нийт 4 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 91,6%. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх болон ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар 2026 оны эхний хагас жилд ТУЗ-өөс нийт 32 тогтоол шийдвэрийг баталсан.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2026 оны эхний хагас жилд биечлэн болон цахим хэлбэрээр нийт 8 удаа хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажиллаж байна.

III. Компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилт, өөрийн үнэлгээ, хянан баталгаажилт

Компанийн засаглалын зарчмуудыг зөв зохистой хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдолтой. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийг нээлттэй хувьцаат компани дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй нийт 112 хувьцаат компанийн кодексийн хэрэгжилтийн 2025 оны жилийн дундаж үнэлгээ 61.8 хувьтай гарсан бол Монложистикс Холдинг ХК-ийн кодексийн хэрэгжилт 93,1% буюу засаглалын хувьд эрсдэлгүй гэсэн үнэлгээг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажуулсан.

IV. Хяналт

Монложистикс Группийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцыг бэхжүүлж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Дотоод аудитын дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталлаа. Уг төлөвлөгөө нь глобал дотоод аудитын стандарт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон хүлээлтэд нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд компани үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоотой уялдсан болно.

Дунд хугацааны стратегийн тэргүүлэх чиглэл нь:

- Эрсдэлд суурилсан аудитын төлөвлөлт
- Чанар ба стандартад нийцүүлэлт
- Мэдээллийн технологи ба дата анализ
- Хүний нөөц ба чадавх
- Хамтын ажиллагаа ба уялдаа холбоо

байхаар тодорхойлж, дотоод аудитыг эрсдэлд суурилсан байдлаар төлөвлөхөд анхаарах, гол бизнесийн процессын үлдэгдэл эрсдэлийн түвшинг 3 жилийн хугацаанд 15%-иар бууруулахад хувь нэмэр оруулах, өндөр эрсдэлтэй зөвлөмжийн хэрэгжилтийн хувийг өсгөх замаар Дотоод аудитын нэгжийг компанийн стратегийн шийдвэр гаргалтад өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ, зөвлөх үүргээр оролцдог, бодлогын түвшинд нөлөөтэй стратегийн түнш болгон төлөвшүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Дунд хугацааны стратегийн хүрээнд 2026 оны дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, хамрах хүрээний дагуу эхний хагас жилд ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг үнэлэх, үр дүнтэй, үр нөлөөтэй байдлыг хангах, сайжруулах боломжийг тодорхойлох тогтолцооны дотоод аудит болон эрсдэл, засаглал ба хяналтын орчны хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх хараат бус дотоод аудитор ажиллалаа.

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Монложистикс Холдинг ХК нь 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 23.6% /хорин гурав аравны зургаа/ хувь буюу 2,269,152,832.60 /хоёр тэрбум хоёр зуун жаран есөн сая нэг зуун тавин хоёр мянга найман зуун гучин хоёр төгрөг жаран мөнгө/ төгрөгийг Компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Нэгж хувьцаа тус бүрд 5.80 /таван төгрөг наян мөнгө/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар зарласан бөгөөд ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосон. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан олголоо.



ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨР

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь 4,8 сая ширхэг хувьцаагаа нэгж бүрийг нь 210 төгрөгөөр үнэлж нээлттэй зах зээл дээрээс эргүүлэн худалдаж авахаа зарласан билээ. Хувьцаагаа халаасалсны үр дүнд хувьцааны эрэлт нэмэгдэж, арилжааны идэвхжил сайжрах, хувьцааны үнэ тогтвортой байх, өсөх, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр амжилттай хэрэгжиж дууслаа. 2026 оны 3 дугаар сарын 31-нийг хүртэл сунгасан уг хөтөлбөрийн хүрээнд нийт 1,009,086,331.10 (нэг тэрбум есөн сая наян зургаан мянга гурван зуун гучин нэгэн төгрөг арван мөнгө) төгрөгөөр, нийт 5,309,118 ширхэг хувьцааг нээлттэй зах зээлээс эргүүлэн худалдан авч халааслаад байна.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангийн үзүүлэлт (сая ₮)	2024 Н1	2025 Н1	2026 Н1
Борлуулалтын орлого	141,982	142,397	152,489
Борлуулалтын өртөг	(130,264)	(130,038)	(140,212)
Нийт ашиг	11,718	12,359	12,277
Борлуулалт, Удирдлагын зардал	(4,156)	(5,197)	(4,972)
Бусад орлого (зардал)	0	2,446	(122)
Үйл ажиллагааны цэвэр ашиг	7,562	9,608	7,184
Санхүүгийн орлого (зардал)	27	(843)	247
Татварын өмнөх цэвэр ашиг (EBT)	7,590	7,557	7,431
ОАТ-н зардал	(943)	(1,208)	(910)
Татварын дараах цэвэр ашиг (NI)	6,646	10,022	6,521
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
Цэвэр ашиг	6,646	7,557	6,521
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	4,993	5,211	5,068
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,653	2,347	1,453
Бүх дэлгэрэнгүй орлого			
Бусад дэлгэрэнгүй орлого	24		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			(11)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	6,670	7,557	6,510
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	5,017	5,211	5,057
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,653	2,347	1,453
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	6,670	7,557	6,510

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт (сая ₮)	2024	2025	2026 Н1
Мөнгөн хөрөнгө	8,709	12,288	3,918
Дансны авлага	40,036	45,546	60,286
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,811	375	3,876
Бараа материал	8,025	4,503	11,761
Урьдчилж төлсөн төлбөр	21,257	10,436	18,455
Бусад эргэлтийн хөрөнгө	2,242	1,886	1,823
Эргэлтийн хөрөнгө	82,080	75,033	100,120
Үндсэн хөрөнгө	5,466	14,472	13,949
Ашиглах эрх бүхий хөрөнгө	3,463	3,518	3,518
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,347	1,219	1,071
Гүүдвил	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгө	10,275	19,209	18,538
Нийт хөрөнгө	92,355	94,242	118,658
Дансны өглөг	18,276	14,609	17,220
Урьдчилж орсон орлого	-	-	-
Богино хугацаат зээл	6,906	9,336	19,368
Бусад өглөг	12,070	5,790	10,914
Богино хугацаат өр төлбөр	37,253	29,736	47,502
Урт хугацаат өр төлбөр	6,452	9,352	11,978
Нийт өр төлбөр	43,705	39,088	59,481
Эздийн өмч	42,325	47,041	49,530
Хяналтын эрхгүй хувь оролцоонд	6,325	8,113	9,647
Нийт Эздийн өмч	48,650	55,154	59,177
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	92,355	94,242	118,658

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт (сая.₮)	2024	2025	2026 Н1
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн	286,243	307,557	178,511
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	259,445	286,357	149,755
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	15	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	167	177	77
Буцаан авсан албан татвар	926	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	25,690	21,023	28,679
Мөнгөн зарлагын дүн	299,841	301,361	195,230
Ажиллагчдад төлсөн	7,616	9,828	4,737
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,921	2,429	1,229
Бараа материал худалдан авахад төлсөн	38,682	57,453	43,706
Ашиглалтын зардалд төлсөн	95	219	83
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	171,759	180,284	94,956
Хүүний төлбөрт төлсөн	371	2,623	1,560
Татварын байгууллагад төлсөн	12,310	23,221	13,786
Даатгалын төлбөрт төлсөн	342	419	164
Бусад мөнгөн зарлага	66,745	24,884	35,009
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,598)	6,196	(16,719)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
	2024	2025	2026 Н1
Мөнгөн орлогын дүн	1,416	8,519	6,326
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	215	242	1,260
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	3,109	-	2,200
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	500	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,708	7,687	2,629
Хүлээн авсан хүүний орлого	1,233	590	237
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
ХО бусад мөнгөн орлого	190	-	-
Мөнгөн зарлагын дүн	24,418	10,133	9,175
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,862	3,232	347
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	130	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	7,292	1,334	5,899
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	46	1,025	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	9,087	4,542	2,930
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,462)	(1,614)	(2,850)

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

	2024	2025	2026 H1
Мөнгөн орлогын дүн	59,527	83,630	83,630
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	59,527	83,467	99,121
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	163	2,000
Төрөл бүрийн хандив	0	-	-
Бусад санхүүгийн мөнгөн орлого	-	-	-
Мөнгөн зарлагын дүн	44,385	84,369	89,551
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	39,743	39,743	87,068
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	785	785	226
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-	212
Төлсөн ногдол ашиг	3,823	3,823	2,045
Бусад санхүүгийн мөнгөн зарлага	34	34	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,142	(739)	15,142
Валютын ханшийн зөрүү	(495)	(265)	(371)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(13,413)	3,579	(8,369)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,122	8,709	8,709
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,709	12,288	3,918

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн үзүүлэлт (сая ₮)	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	119	(1,427)	10,188	(307)	33,753	42,325	6,325	48,650
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	6,705	6,705	2,692	9,397
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	1,692	1,692	(905)	788
Халаасны хувьцаа	-	(1,960)	-	-	-	(1,960)	-	(1,960)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	296	-	296	-	296
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(2,017)	(2,017)	-	(2,017)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	119	(3,388)	10,188	(11)	40,133	47,041	8,113	55,154
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,068	6,705	5,068	1,453	6,521
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(212)	1,692	(212)	82	(130)
Халаасны хувьцаа	-	(217)	-	-	-	(217)	-	(217)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(2,151)	(2,017)	(2,151)	-	(2,151)
2026 оны 6-р сарын 30-ны үлдэгдэл	119	(3,605)	10,188	(10)	42,838	49,530	9,647	59,177

Холбоо барих

Telephone: +976 7701-5454

Website: www.mlholding.mn

Хаяг

Монгол улс, Улаанбаатар хот,

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

Нью горизонтс оффис,

11 давхар, 1101 тоот